

3-Р СОНГОЛТ: ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГ, ЕСҮС ХРИСТ ХОЁР МАХ ХИЙГЭЭД ЯСАН БИЕТЭЙ. АРИУН СҮНС БОЛ СҮНСЭН ХҮН.

Судлах эх сурвалж

Сургаал ба Гэрээ 130:22–23, Матай 3:13–17; Үйлс 7:55–56-г тус тус үзнэ үү.

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч **Жэффри Р.Холланд** ийн заасан.



Бид эдгээр тэнгэрлэг гурван хувь хүн зорилго, арга зам, гэрчлэл, үүргээрээ нэгдмэл Бурхан тэргүүтнийг бүрдүүлдэг гэдэгт итгэдэг. Бид Тэднийг нигүүлсэл, хайр, шударга ёс, ач ивээл, тэвчээр, өршөөл, гэтэлгэлийн яг ижил бурханлаг мэдрэмжээр дүүрэн гэдэгт итгэдэг. Тэднийг нэгэн материд нэгдсэн гурван хүн гэж итгэхээс *бусдаар* бол Тэд бидний зөвхөн төсөөлж л чадах нэн чухал бөгөөд мөнхийн бүх зүйлд нэг хүн мэт нэгдмэл байдаг гэдэгт бид итгэдэг хэмээн хэлэх нь оновчтой гэж би боддог. . . . Эцэг, Хүү, Ариун Сүнс гурав гурвуулаа тус тусдаа хүн, гурван бурханлаг хүмүүн гэдэг нь судруудаас нотлогддог болохыг бид тунхаглаж байна. (Jeffrey R. Holland, “The Only True God and Jesus Christ Whom He Hath Sent,” *Liahona*, Nov. 2007, 40–41)